

ХҮНС, ХӨДӨӨ, АЖ АХУЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙДЫН ТУШААЛ

**2017-2018 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний
нэр, төрөл тоо, хэмжээг тогтоох тухай**

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2017-2018 онд экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг 1 дүгээр, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг 2 дугаар хавсралтад заасны дагуу тус тус тогтоосугай.

2. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ын дагуу зохион байгуулахыг ХҮБХЗГ-ын дарга, ажлын хэсэг /Т.Гантогтох/-т даалгасугай.

3. Тушаалыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/-т үүрэг болгосугай

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын
2017 оны 11-р сарын-ны өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ,
АНГИЛЛЫН КОД**

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1.	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсвэл хөргөсөн мах	0201.10.00	27900 тонн (хорин долоон мянга есөн зуу)
2.		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсвэл хөргөсөн мах	0201.20.10	
3.		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсвэл хөргөсөн мах	0201.30.10	
4.		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5.		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6.		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7.		Сарлагийн ястай нь хэсэглэсэн шинэ эсвэл хөргөсөн мах	0201.20.20	
8.		Сарлагийн ясгүй шинэ эсвэл хөргөсөн мах	0201.30.20	
9.		Сарлагийн ястай хөлдүү мах	0202.20.20	
10.		Сарлагийн ясгүй хөлдүү мах	0202.30.20	
11.	Адууны мах	Адууны ястай шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.11	43600 тонн (дөчин гурван мянга зургаан зуу)
12.		Адууны ясгүй (шулсан) шинэ, хөргөсөн, хөлдүү мах	0205.00.12	

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2017 оны 11-р сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**2018 ОНД ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ,
АНГИЛЛЫН КОД**

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	тоо хэмжээ
1.	Үхрийн мах	Үхрийн гулууз болон өрөөл шинэ эсвэл хөргөсөн мах	0201.10.00	500 тонн (таван зуу)
2.		Үхрийн ястай нь хэсэглэсэн шинэ эсвэл хөргөсөн мах	0201.20.10	
3.		Үхрийн ясгүй хэсэглэсэн, шинэ эсвэл хөргөсөн мах	0201.30.10	
4.		Үхрийн гулууз болон өрөөл, хөлдүү мах	0202.10.00	
5.		Үхрийн ястай нь хэсэглэсэн, хөлдүү мах	0202.20.10	
6.		Үхрийн ясгүй хөлдүү мах	0202.30.10	
7.	Хуурай сүү	Хуурай сүү	0402.21.10	4218 тонн (дөрвөн мянга хоёр зуун арван найм)
8.	Гурил	Улаанбуудай-хөх тарианы гурил (меслин)	1101.00.20	1000.0 тонн (нэг мянга)
9.	Хүнсний улаанбуудай	Үрийн хатуу улаанбуудай	1001.11.00	225000 (хоёр зуун хорин таван мянга)
10.		Үрийн зөөлөн улаанбуудай	1001.91.10	
11.	Үрийн улаанбуудай	Үрийн хатуу улаанбуудай	1001.11.00	10000 тонн (арван мянга)
12.		Үрийн зөөлөн улаанбуудай	1001.91.10	